

"АВЛИГЫН ЭСРЭГ НИЙСЛЭЛИЙН ХӨТӨЛБӨР"-ИЙН ХЭРЭГЖИЛТ

**НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБА
(2017 оны жилийн эцсийн байдлаар)**

2017.12.11

№	Хөтөлбөрийн агуулга	Гүйцэтгэл
1.	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 23/01 дугаар тогтоол “Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр”	Хөтөлбөрийн зорилго: Төрөөс авлигын эсрэг баримталж буй бодлого, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог хангах, нийслэлээс авлигын эсрэг нэгдсэн бодлогыг тодорхойлох, авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, чирэгдэлгүй хүргэх, сайн засаглалыг бэхжүүлэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Том төрөөс ухаалаг төр рүү” санаачилга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн авлигын талаарх зөвлөмжийг хэрэгжүүлэх, шударга, хариуцлагатай, ил тод, нээлттэй Улаанбаатар хот болох зорилтыг хэрэгжүүлэх, нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны боло нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтан, иргэд, олон нийтийг авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хандлага, үзэл санааг төлөвшүүлэх, ил тод нээлттэй, бүтээмжтэй, хариуцлагатай, иргэний нийгмийн оролцоог хангах;
2.	Санхүүжилтийн эх үүсвэр	Байгууллагын тухайн жилийн батлагдсан төсөв
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, дүүргийн Засаг даргын Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлаг, харьяа байгууллага I үе шат 2015-2016 он II үе шат 2017-2020 он Авлигатай тэмцэх газар, Олон улсын байгууллага, Төрийн бус байгууллагууд
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд	Зорилт 1. Ил тод, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, авлигагүй, нийслэлийн нутгийн өөрөө удирдах ёсны болон нутгийн захиргааны байгууллагын нийтийн албыг бэхжүүлэх Зорилт 2. Нийтийн албыг улс төр, эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллөөс ангид байлгаж, мэргэшсэн албан хаагч болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажилтнуудын баталгааг хангаж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх Зорилт 3. Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудын төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа болон зөвшөөрөл олголтыг олон нийтэд ил тод нээлттэй, хяналттай болгох Зорилт 4. Нийслэлийн өмчийг удирдлага, бүртгэл, хяналт, үнэлгээний нэгдсэн, ил тод тогтолцоотой болгох, хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх, зарим өмчийг хувьчлах, төрийн аж ахуйн үйл ажиллагааг хязгаарлах;

		<p>Зорилт 5. Хотын амьдралын олон талт асуудлыг зохицуулсан “Дүрэмтэй хот” хөтөлбөрийг хэрэгжүүлэх</p> <p>Зорилт 6. Авлигын эсрэг ил тод Улаанбаатар академийг байгуулж, иргэд, олон нийтийн авлигын талаарх боловсролыг нэмэгдүүлж, соён гэгээрүүлэх ажлыг өргөнөөр зохион байгуулах</p> <p>Зорилт 7. Нийслэлийн бүх шатны байгууллагын нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах, авлигын болон эрсдлийн хөндлөнгийн үнэлгээ хийдэг тогтолцоонд шилжих</p>		
5.	Зардал			
		Төсөв (он) 2015	Төсөв (он) 2016 2017	Төсөв (он)
		-	-	-
	Зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт		
	<p>1-р зорилтын хүрээнд:</p> <p>1. Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> <p>1.1.1 Нутгийн захиргааны байгууллагууд нь авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, зохион байгуулалтын шинэлэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж ажиллах</p>	<p>Жил бүр байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд “Байгууллагын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох, эрх зүйн орчинг сайжруулах: Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж тусган ажилладаг.</p> <p>АТГ-аас зохион байгуулсан “Мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах ЭБАТ-ны сургалт”-д байгууллагын ЭБАТ хамрагдсан бөгөөд АТГ-т хүсэлт гаргаснаар 2017.11.29-нд байгууллагын 17 албан хаагчийг Авлигын эсрэг хууль тогтоомж, төрийн албан хаагчдын ёс зүйн талаар сургалтад хамруулсан.</p>		
6.	<p>4. Төрийн бус байгууллагаас санаачилсан авлигын эсрэг ил тод байдлын түншлэлд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд нэгдэх, хамтран ажиллах;</p> <p>1.4.2 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэрүүдийн ил тод, нээлттэй байдал, албан тушаалтны хариуцлага ба авлигын эрсдлийн үнэлгээг ИНБ-аар тогтмол хийлгэх</p>	<p>Байгууллагаас гарч буй шийдвэрүүдийн ил тод, нээлттэй байдал, албан тушаалтны хариуцлага ба авлигын эрсдлийн үнэлгээг иргэний нийгмийн байгууллагуудаар тогтмол хийлгэх зардал байгууллагын тухайн жилийн төсөвт орж батлагддаггүй.</p>		
	<p>6. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цахим хуудасны ашиглалтыг сайжруулах, заавал байх мэдээллийн агуулгыг тогтоох, мэдээлэл түгээх бүхий л арга хэрэгслийг бүрэн ашиглах, байнга шинэчлэх, хайлт хийхэд</p>	<p>Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор байгууллагын цахим хуудсанд байгууллагын танилцуулга, шинэчилсэн дүрэм, эрхэм зорилго, стратегийн зорилт, бүтэц зохион байгуулалт, дагаж мөрдөж буй хууль тогтоомж, дүрэм журам, холбоо барих хаяг, утасны дугаар, цахим хаяг, албан хаагчдын мэдээлэл, Нийслэлийн Дотоод аудитын албаны 2016 оны үйл ажиллагааны 12 төрлийн тайлан, байгууллагын дунд хугацааны төлөвлөгөө, 2017 оны</p>		

<p>хялбар болгох, www.ulaanbaatar.mn цахим хуудасны мэдээллийг төрөлжүүлэх; 1.6.2. Заавал байх мэдээллийн жагсаалт гаргах 1.6.3. Хайлт хийх боломжийг нэмэгдүүлэх 1.6.5. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг биечлэн, цахим хуудсаар, мессеж, телевиз, радио, сонин, сэтгүүл, эмхтгэл, гарын авлага, тараах хуудас, мэдээллийн самбар гэх мэт мэдээлэл түгээх бүхий л арга хэрэгслийг бүрэн ашиглан иргэдэд мэдээллэх тогтолцоог сайжруулах</p>	<p>үйл ажиллагааны төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын төлөвлөгөө, цаг үеийн мэдээ мэдээллүүд, дотоод аудитын талаарх ойлголт, гарын авлага, стандарт, заавар, загвар, үйл ажиллагаандаа мөрддөг хууль тогтоомж, ёс зүйн дүрмүүд, санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан тухай болон бусад холбогдох мэдээллийг хуулийн хугацаанд нь цахим хуудсанд байршуулсан.</p> <p>Мөн шилэн дансны тухай хуулийн дагуу аудит, хяналт шалгалтын багт ажилласан албан хаагчдын “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-ийг www.shilendans.gov.mn цахим хуудсанд хуулийн хугацаанд оруулсан. Дээрх мэдээллүүдийг өөрчлөгдсөн тухай бүр шинэчлэн оруулж байна.</p>
<p>2-р зорилтын хүрээнд: 1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагад улс төрийн томилгоог зогсоох, улс төр эдийн засаг, хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах, мэргэшсэн албан хаагчдаар нийтийн албыг бэхжүүлэх; 2.1.1. Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулах, 2.1.2. Улс төрийн томилгооноос бусад албан тушаалтны аливаа томилгоог “Мерит зарчим” буюу улс төрийн хуваарилалт, захиалгаар бус, түүнээс бүрэн ангид шударгаар өрсөлдүүлэн шалгаруулах хэлбэрт шилжүүлэх 2.1.5. Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, дүгнэлгүйгээр албан тушаалд томилсон тохиолдолд томилгоо хийсэн албан тушаалтанд хариуцлага тооцож нийтэд мэдээлж ажиллах</p>	<p>2015 онд Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс гаргасан тогтоол шийдвэрийг дагуу 5 албан хаагчийг томилж, 3 албан хаагч төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн бол, 2016 онд 2, 2017 онд 1 албан хаагчийг нэр дэвшүүлж томилон, төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргүүлсэн байна.</p> <p>Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянаж, дүгнэлгүйгээр албан тушаалд томилсон тохиолдолд байхгүй бөгөөд 2015 онд 11 албан хаагчийн, 2016 онд 8 албан хаагчийн, 2017 онд 3 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг АТГ-аар хянуулж томилсон.</p>
<p>2. Албан хаагчийн эрх зүйн болон нийгмийн баталгааг хангаж, тогтвортой ажиллуулах нөхцөлийг бүрдүүлэх; 2.2.5. Төрийн албан хаагчийг</p>	<p>Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд 2015 онд албан хаагчдын нийгмийн баталгааны суурь судалгааг хийж, давхардсан тоогоор 13 албан хаагчид нийт 7.8 сая төгрөгийн нэг удаагийн дэмжлэг, тусламж олгосон. Гэр хороололд амьдардаг, нийслэлийн байгууллагад олон</p>

<p>хууль бусаар ажлаас халах, тушаал бууруулах, хууль ёсны эрх ашгийг нь хохироох, нэр төр, алдар хүндийг нь гутаах зорилгоор үндэслэлгүйгээр санаатай гүтгэсэн тогтоогдвол нэр төрийг нь сэргээлгэхээр хамт олон, олон нийтэд мэдээлдэг тогтолцоог бий болгох</p> <p>2.2.6. Албан хаагчдын орон сууцны судалгаанд үндэслэж орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад банкны зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх</p>	<p>жил ажилласан 2 албан хаагчид “Улаанбаатар орон сууц сан”-аас манай байгууллагад олгосон квотын дагуу орон сууцны урьдчилгаа төлбөрийн 50% буюу 22.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.</p> <p>2016 онд байгууллагын нэг удаагийн тэтгэмж, урамшуулалд 21,700.0 мянган төгрөгийн төсөв батлуулсан бөгөөд 3 албан хаагчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд зааснаар нийт 1,634.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж, тусламж олгосон. Бүх албан хаагчдыг 4,988.0 мянган төгрөгийн зардал гарган эрүүл мэндийн бүрэн үзлэг, шинжилгээнд хамруулсан. Түрээсийн байранд амьдардаг нийслэлийн байгууллагад олон жил ажилласан 1 албан хаагчид “Улаанбаатар орон сууц сан”-аас манай байгууллагад олгосон квотын дагуу орон сууцны урьдчилгаа төлбөрийн 50% буюу 10.0 сая төгрөгийн дэмжлэг олгосон.</p>
<p>3. Албан хаагчийн ажлын бүтээмжид чиглэсэн гүйцэтгэлийн хяналтын горимд шилжүүлэх, ажлын үр дүнгээр урамшуулах журмыг шинэчлэн мөрдүүлэх;</p> <p>2.3.1. Сайн засаглалын стандартыг нийтийн албанд нэвтрүүлж, иргэддээ чанартай үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн, тогтвортой, төрийн албан хаагчийг бүх шатанд бэлтгэх</p>	<p>2015 онд 21 албан хаагчтай үр дүнгийн гэрээ, 1 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулан гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, нийт 29.3 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгон, 8 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг ахиулсан. Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг нь харгалзан, болзол шаардлагыг хангасан албан хаагчдыг зохих шагналд тодорхойлсноор Хөдөлмөрийн хүндэт медалиар 1, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр 4, Нийслэлийн 376 жилийн ойн медалиар 5, НИТХ-ын шагналаар 2, нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 3, МЗХ-ны “Тэргүүний залуу” алтан медалиар 1, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газрын “Шилдэг залуу” медалиар 2 албан хаагч тус тус шагнуулж, “Оны шилдэг ажилтан”-аар 3, “Оны шилдэгийн шилдэг ажилтан”-аар албан хаагчийг тодруулж мөнгөн шагналаар шагнасан.</p> <p>2016 онд 21 албан хаагчтай үр дүнгийн гэрээ, 1 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангуулан гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, нийт 11.1 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгон, төрийн захиргааны албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг шинээр 3 албан хаагчид олгож, 3 албан хаагчийн зэрэг дэвийг ахиулсан. Төрийн жинхэнэ албан хаагчийг тангарагийг 2 албан хаагч өргөсөн. Албан хаагчдын мэргэжлээрээ ажилласан жил, ажлын туршлага, амжилтыг нь харгалзан болзол, шаардлагыг хангасан 1 хүнийг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор, 3 хүнийг Сангийн яамны “Нягтлан бодох бүртгэлийн тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон. Байгууллагын 2015 оны үйл ажиллагааны үр дүнгээр “Бүрэн хангалттай” үнэлүүлсний урамшуулалд удирдлагын багт 4,500.0 мянган төгрөг олгосон.</p> <p>2017 онд албан хаагчдын ажлын гүйцэтгэлтэй нь уялдуулж хагас, бүтэн жилээр албан хаагчдын үр</p>

	<p>дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээг дүгнэж, 16.1 сая төгрөгийн урамшуулал олголоо. Төрийн захиргааны албан хаагчдад олгох зэрэг дэвийг шинээр 1 албан хаагч авч, 6 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, 3 албан хаагчийн цалингийн шатлал, 1 албан хаагчийн албан тушаалын зэрэглэлийг ахиулж, 1 албан хаагч тангараг өргөж, төрийн жинхэнэ албан хаагч болсон. Мөн тогтвор суурьшилтай, идэвх зүтгэлтэй ажилласныг үнэлэн НИТХ-ын шагналаар 1, нийслэлийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 1 албан хаагчийг шагнаж, Сангийн яамны “Жуух бичиг”-ээр 4 албан хаагчийг, “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдэг, төрийн дээд шагнал “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор тус тус 1 албан хаагчийг шагнуулахаар тодорхойлж, материалыг зохих байгууллагад хүргүүлсэн. Мөн албан хаагчдын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний жилийн эцсийн биелэлт, үнэлгээг харгалзан 2 албан хаагчийг “Оны шилдэг ажилтан”, 2 албан хаагчийг “Оны шилдэгийн шилдэг ажилтан”-аар шалгаруулан мөнгөн шагналаар шагнахаар тодруулаад байна.</p>
<p>4. Албан хаагчийн сэтгэлгээ хандлагыг өөрчлөх, мэргэшүүлэх; 2.4.3. Албан хаагчийг чадавхижуулах, сургалтад хамруулах ажлыг шат дараатай зохион байгуулах</p>	<p>Нийслэлийн Дотоод аудитын албанаас Төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг жил тутам батлан хэрэгжүүлж, 2015 онд давхардсан тоогоор нийт 126 албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалтад хамруулж, үүнтэй холбоотойгоор 5,935.0 төгрөгийн зардал гаргасан. 2016 оны сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр төсөвт 10.0 сая төгрөгийг батлуулж, давхардсан тоогоор нийт 108 албан хаагчийг мэргэжлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх төрөл бүрийн сургалтад хамруулснаас 16 албан хаагчийн сургалтын төлбөрт 4,650.0 мянган төгрөг зарцуулсан. 2017 онд албан хаагчдыг хөгжүүлэх сургалтын зардалд 5,5 сая төгрөгийг батлуулж, давхардсан тоогоор нийт 173 албан хаагчийг төрөл бүрийн сургалтад хамруулсан.</p>
<p>5. Ажлын байран дахь ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдлийг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлэх; 2.5.1."Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан тушаалтнуудын иргэдтэй хийх уулзалтад ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай журам" -ын хэрэгжилтийг хангуулах 2.5.2. Ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл бүхий албан тушаалын жагсаалтыг тогтмол гаргах 2.5.3. Үнэлгээний хороо, ажлын хэсэг, уралдаант</p>	<p>Нийслэлийн Дотоод аудитын албаны удирдлага байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн онцлогоос шалтгаалан иргэдтэй уулзалт хийдэггүй. 2015 онд байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог шинэчлэн байгуулж, нийт албан хаагчдад холбогдох ёс зүйн дүрмийг таниулан ажилласан. 2015 оны байдлаар албан хаагчид төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн ажилласнаар ёс зүйн зөрчлийн талаар гомдол гараагүй. Албан хаагчдын хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, аудитор, шинжээчдийн аудит эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 100 орчим мэдэгдлийг авч холбогдох хууль, журмын дагуу бүртгэн, тайлагнасан. 2016 онд байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог дахин шинэчлэн байгуулж, нийт албан хаагчдад холбогдох ёс зүйн дүрмийг таниулан ажилласан бөгөөд иргэнээс албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаарх нэг гомдол</p>

<p>шалгаруулалтад орж байгаа албан хаагчдын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг гаргуулж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>2.5.4. Захиргааны акт гаргах, удирдах, хяналт шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцохын өмнө тус бүр ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргаж хэвших</p>	<p>ирснийг журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, хариуг иргэнд хүргэсэн. Нийслэлийн авлигын эсрэг 2016 оны төлөвлөгөөтэй уялдуулан байгууллагын хэмжээнд авлигын эсрэг авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны шинэчилсэн жагсаалтын дагуу давхардсан тоогоор 14 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг, 8 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 103 мэдэгдэл хүлээн авч, АТГ-ын програмд бүртгэн, тайлан мэдээг зохих хугацаанд гаргаж өгсөн.</p> <p>2017 онд байгууллагын дэргэдэх Ёс зүйн хороог дахин шинэчлэн байгуулсан. АТГ-ын даргын тушаалаар батлагдсан хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтны жагсаалтын дагуу 12 албан хаагчийн 2016 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд нь хүлээн авч, тайлан мэдээг гаргаж өгсөн. Оны эхний 11 сарын байдлаар аудитор, шинжээчдээс аудитын ажил эхлэх бүрт ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай 96 мэдэгдэл хүлээн авч, АТГ-ын програмд бүртгэсэн.</p>
<p>3-р зорилтын хүрээнд:</p> <p>1. Төсвийн орлого, зарлага болон өр, зээл, өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой аливаа мэдээллийг олон нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгох, нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллага, өмчит үйлдвэрийн газар, компаниудыг "Шилэн данс"-ны тогтолцоонд шилжүүлэх;</p> <p>3.1.1. "Шилэн дансны тухай" хуулийг хэрэгжүүлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах</p> <p>3.1.2. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын төсөв санхүү, орлого, зарлага, өр, зээл болон өмч, хөрөнгийн зарцуулалттай холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод сурталчлан сайтад нээлттэй байршуулж, хяналттай болгон "Шилэн данс"-ны тогтолцоонд шилжүүлэх</p>	<p>Шилэн дансны тухай хуулийн дагуу байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ болон жилийн төсөв, хөрөнгөтэй холбоотой тушаал шийдвэр, санхүүгийн тайлан, таван сая төгрөгөөс дээш гүйлгээ, холбогдох хуулиар оруулах бусад мэдээллийг хуулийн хугацаанд shilendans.ub.gov.mn сайтад байршуулж хэвшсэн.</p> <p>2015 онд НДАА нь Монгол улсын Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйл, нийслэлийн Засаг даргын 2015 оны А/01 дүгээр захирамжийн дагуу нийслэлд харьяалагдах 89 байгууллага /төсөвт-69, ОНӨААТҮГ-20/-д үзлэг шалгалтыг явуулсан.</p> <p>2015 оны эхний хагас жилийн үзлэг шалгалтыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад Засаг даргын удирдамжаар баримт материалуудыг татан авч шилэн дансны нэгдсэн сайт www.shilendans.gov.mn, болон нийслэлийн www.shilendans.ub.gov.mn цахим хуудсанд байршуулсан мэдээлэлтэй тулган үзлэг шалгалтыг гүйцэтгэж, дүнг нийслэлийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан. Тус хурлын тэмдэглэлийг үндэслэн НЗД-ийн захирамжаар мэдээллээ оруулаагүй 2 байгууллагын захиралд сануулах сахилгын арга хэмжээ авсан.</p> <p>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн нэгдсэн үзлэг шалгалтаар илэрсэн зөрчлийг тухай бүр залруулан ажилласан. Мэдээлэл дутуу оруулсан байгууллагын хариуцсан албан тушаалтантай тухай бүр холбогдон нөхөн оруулж дээрх алдаа зөрчлийг дахин давтан</p>

		<p>гаргахгүй байхыг анхааруулж зөрчлийг арилгуулан ажилласан.</p> <p>2016 онд нийслэл болон дүүргүүдийн дотоод аудитын албад нь нийслэл, дүүргийн нийт 517 байгууллагын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавин ажиллаж, мөн Сангийн яаманд улирал бүр Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн хүргүүлсэн. Нийслэлийн харьяа төсөвт 44, ОНӨААТҮГ-23 нийт 66 байгууллагын Шилэн дансны тухай хууль, журмын 2016 оны 1-11 сарын хэрэгжилтэнд сар бүр хяналт тавьж ажилласан. Шилэн дансны 2015 оны жилийн эцсийн үзлэг шалгалтыг 2016 оны 5 дугаар сард явуулсан. Үзлэг шалгалтын явцад нийслэлийн хэмжээнд нийт 70 тэрбум 102.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж тухай бүр залруулуулсан. Тус үзлэг, шалгалтын дүнг нийслэл болон 9 дүүргээр нийт 517 байгууллагын мэдээллийг нэгтгэн 2016 он 05 сарын 26-нд удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулсан бөгөөд хуулийн дагуу шилэн дансны цахим хуудсанд мэдээллүүдээ хугацаа хоцроож байршуулдаг нийтлэг зөрчил дутагдал байгаад зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж байна.</p> <p>2017 онд НДАА-ны аудитын баг Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийн аудитыг гүйцэтгэхдээ http://shilendans.gov.mn/ цахим хуудсанд харьяа байгууллагуудын байршуулсан мэдээллийг аудитын дуусгавар хугацаа болох 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар баримтжуулсан ба цахим хуудсанд байршуулсан мэдээллийг тухайн байгууллагын санхүүгийн болон бусад холбогдох баримтуудтай харьцуулан тулгаж бүрэн, үнэн зөв эсэхийг магадласан. Энэхүү үзлэг шалгалтаар тус хууль болон журмыг хэрэгжүүлээгүй, хангалтгүй хэрэгжүүлж байгаа нийт 4 байгууллагад албан шаардлага хүргүүлээ.</p> <p>Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг үнэлж, дүгнэх 2017 оны нэгдсэн шалгалтаар илэрсэн дээрх алдаа зөрчлүүдийн дийлэнх хувь нь тухайн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийж, холбогдох ажилтан, албан хаагчид шинэчлэгдсэнтэй холбоотойгоор гарсан нь аудитын явцад ажиглагдсан. Аудитын баг байгууллагуудад ажиллах явцад тухай бүр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулсан ба цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгч ажилласан.</p>
	<p>2. Төсвийн төлөвлөлтийн үр ашигтай байдал, гүйцэтгэлийн хэмнэлт, зарцуулалт дахь хөндлөнгийн хяналт, оролцоог нэмэгдүүлж, дотоод аудитын хяналтыг боловсронгуй болгох; 3.2.1. Дотоод аудитын хяналтыг тогтолцоог боловсронгуй болгох</p>	<p>2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 42 байгууллагад хийсэн аудитын ажлын хүрээнд 391 зөвлөмж хүргүүлж, нийт 30,099.4 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 27,165.8 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 2,905.3 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 28.3 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан.</p>

	3.2.2. Төсвийн зарцуулалт хэмнэлтийн талаар тусгай вэб хуудастай болох /цахим хуудсандаа “байгууллагын төсөв” гэсэн цэс суулгах/	2016 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 42 байгууллагад хийсэн аудитын ажлын хүрээнд 263 зөвлөмж хүргүүлж, нийт 11,190.3 сая төгрөгийн зөрчил илрүүлснээс 10,356.2 сая төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх, 817.1 сая төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулах, 17.0 сая төгрөгийн зөрчлийг акт тогтоож, төсөвт буцаан төвлөрүүлэхээр холбогдох байгууллагуудад дүгнэлт, зөвлөмж өгч ажилласан. Дээрх зөвлөмжүүдийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 2016 оны эцсийн байдлаар өгсөн нийт 263 зөвлөмжөөс хугацаандаа хэрэгжсэн 181, хугацаа болоогүй 71, хугацаандаа хэрэгжээгүй 11 зөвлөмж байсан. НДАА нь Нийслэлийн Дотоод аудитын хорооны даргын баталсан төлөвлөгөөний дагуу 2017 оны 3-р улирлын байдлаар 27 аудит, санхүүгийн хяналт шалгалт, 2 сэдвийн аудит, нийт 29 аудит, хяналт шалгалт хийж, 148,153,763.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлсэнээс 17,765,131.3 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 8,049,190.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэн, 1,851,735.9 мянган төгрөгийн зөрчлийг залруулах, 120,487,705.7 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өгч ажилласан. Дээрх 29 аудит, хяналт шалгалтаар улсын байцаагчийн 17 акт, 8 албан шаардлага, 137 зөвлөмж өгсөн.								
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээллийн ил тод байдал, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл нэмэгдэж, төрөл бүрийн ажил зохион байгуулахаар төлөвлөдөг ч төлөвлөгөөнд тусгасан ажлыг гүйцэтгэхэд шаардагдах төсөв хөрөнгө батлагддаггүй.								
8.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Биелэлт дундаж	Зорил-тын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4	Зорилт 5	Зорилт 6	Зорилт 7
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ	хөтөлбөрийн нэгдсэн								

ХЯНАСАН:

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

ТАЙЛАН ГАРГАСАН:

ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Я.САРАНСҮХ